

**Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийг хэрэгжүүлэх
2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт
/эхний хагас жил/**

2022.06.06

Чойр

Төлөвлөлт, зохион байгуулалт:


Газрын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан. Албан хаагч бүрийн ажлын бүтээмжийг дээшлүүлэх, үүрэг даалгаврын биелэлтийн гүйцэтгэлийг сайжруулах хүрээнд үүрэг даалгаврын дэвтрийг албан хаагч бүрээр хөтөлж сарын тайланд тайлагнаж хэвшүүлсэн.

Дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 2022 оны эхний хагас жилд 10 удаа 14 сэдвээр сургалт зохион байгуулж, байгууллагын 9 албан хаагчид сургалтанд идэвхитэй хамрагдсаны үр дүнд ажлын бүтээмж нэмэгдэж, харилцаа хандлага сайжирсан.

Дотоод сургалт:

1	Төлөвлөлт, түүний ач холбогдол	1 сар	Б.Гандулам
2	Харилцаа ба хандлага		
3	Авлигын тухай хууль, ХАСХОМ гаргах зөвлөмж Угийн бичиг хөтлөх арга зүй		
4	Төрийн албаны хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм		
5	Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах	2 сар	Б.Гандулам
6	Шилэн дансны тухай хууль Анхан шатны баримт бичиг бүрдүүлэлт Байгууллагын соёл		Ц.Цэрэнчимэд Р.Цэндмаа
7	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль Салбарын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг сайжруулах боломж, арга зүй	3 сар	Д.Отгонбаяр Сумдын байгаль хамгаалагч, мэргэжилтэн
8	Хог хаягдлын тухай		Б.Гандулам
9	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль	4 сар	Б.Гандулам
10	Аялал жуулчлалын тухай ойлголт		Р.Цэндмаа
11	Хөдөлмөрийн тухай хууль	5 сар	Н.Намуунцэцэг
12	Мод хэрхэн тарьж ургуулах, ногоон байгууламж бий болгох		Т.Дашцэдэн
13	Усны тухай хууль	6 сар	Н.Намуунцэцэг
14	Өргөдөл, гомдол шийдвэрлэлт		С.Саранчимэг

Шинээр томилогдсон албан хаагчдыг дадлагажуулах удирдамж, хуудас газрын даргаар батлуулан мөрдөж эхлэсэн.





“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах тайлагнах журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан сургагч багшийн сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан.

Идэвхитэй хөдөлгөөн, ажлын байран дээрх дасгалыг тогтмолжуулсан.

Газрын даргын тушаалаар спортын хамтлаг байгуулж, албан хаагчдыг идэвхитэй дасгал, хөдөлгөөн, өглөөний гүйлт алхалтад хамруулан ажиллаж байна.

Монгол бичигт суралцах төлөвлөгөө гарган, Монгол бичгээр хэвлэгдэн гардаг "Хүмүүн бичиг" сониныг уншлагадаа ашиглаж, монгол бичгийн түвшин тогтоох сорил өгч, 1-р сургуулийн багш Э.Олонцэцэгийн Үндэсний бичгээ шамдан сурцгаая ном авсан. Албан хаагчдын 80 хувь нь монгол бичгийн унших, бичих чадвараа сайжруулсан. 20 хувь нь шинээр суралцаж байна. 1 албан хаагч Монгол бичиг минь уралдаанд амжилттай оролцсон.

Даваа	Лхавга	Баасан
Хуулан бичиг, швэр бичгийн цаг	Уншлагын цаг	Үсэг, дүрмийн цаг





Тус газрын албан хаагчдын дунд зарласан "Угийн бичгээ хөтлөцгөө" уралдаанд идэвхитэй хамрагдаж, өөрийн ураг удмаа хамгаалах, үр хүүхдүүддээ өвлүүлэн үлдээх, өвөг дээдсийн ураг удмаа хамгаалах их өв соёлыг хадгалан үлдээх үйлсэд идэвхитэй оролцсон албан хаагчид 2022 онд Боржигин өв музейн 2 арга хэмжээнд дэмжин оролцсон.

Орон нутагт АТГ, АЗДТГ-аас зохион байгуулсан болон БОАЖЯ, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, Боржигин өв музей, Онцгой байдлын газар зэрэг байгууллагаас зохион байгуулсан 11 удаагийн цахим болон танхимын сургалтанд холбогдох албан хаагчид хамрагдсан.


Шинэлэг санал. санаачилгүүд

Шинэ санаа, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх зорилгоор санаачлагыг дэмжин ажиллах удирдамж гаргаж албан хаагчдыг идэвхижүүлсний үр дүнд мэдлэг олгох, ур чадвар сайжруулах, ажлын байранд сургах чиглэлээр дараах шинэлэг ажлуудыг зохион байгуулсан.



Үйл ажиллагаа	Үр дүн
1. “Бие биедээ талархах талархлын өдөр” үргэлжүүлсэн. Энэ өдөр бие биедээ урам өгч, талархлын хуудас солилцоно.	Багаар ажиллаж, бие биедээ урам өгч, талархаж хэвшсэн. Хамт олны нэгдмэл байдал төлөвшсөн.
2. Багаар ажиллах, харилцаа хандлага гарын авлага	Албан хаагчдад урам өгөх зорилгоор ширээн дээр нь байрлуулсан.
3. Тамхигүй хамт олон уриалга	Тамхи татдаг албан хаагч байхгүй болно.
4. “Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй” аян	Хог хаягдлыг бууруулахад манлайлалтай оролцсон.
5. Би ёс зүйтэй албан хаагч	Уриалга постероор цахимд ёс зүйтэй байхыг уриалсан.
6. Идэвхижүүлэлтийн хайрцаг	Албан хаагчдад урам өгөх зорилготой.





Тайлан гаргасан: Ахлах мэргэжилтэн

Б.Гандулам